



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,  
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2024.02.07 № 04/297  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН  
ДАРГА НАРТ

Шийдвэр хүргүүлэх тухай

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Тэтгэмжийн хэмжээг тогтоох тухай” 08, “Шимтгэлийн хэмжээг тогтоох тухай” 09, “Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг тогтоох тухай” 10, “Тогтоол хүчингүй болгох тухай” 12, 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн “Нэрийн дансны 2023 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай” 15, “Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл тогтоох тухай” 20 дугаар тогтоолуудын хуулбарыг тус тус хүргүүлэв.

Батлагдсан тогтоолуудыг судлан байцаагч, ажилтнуудыг мэргэжил арга зүйгээр, ажил олгогч, иргэд, даатгуулагчдыг мэдээллээр ханган ажиллана уу.

Хавсралт 6 хуудастай.

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ,  
СУДАЛГААНЫ ГАЗРЫН  
ДАРГА



Ц.ГАНЦЭЦЭГ



НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

Захирал нь 2024 оны 01 сарын 30-ны өдрийн 1572/2024-д тогтоогдсон

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Г Тэтгэмжийн хэмжээ тогтоох тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг 2 000 000 /хоёр сая/ төгрөгөөр тогтоосугай.
2. Амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг 3 500 000 /гурван сая таван зуун мянга/ төгрөгөөр тогтоосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба /Г.Банзрагч/-нд үүрэг болгосугай.
4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн "Оршуулгын тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 04 дүгээр тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.
5. Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ДАРГА

1118276307  
8284708 & CHA1473

Х.БУЛГАНТУЯА



НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

Захиурагч: 2024 оны 01 сарын 05  
Эхний үеийн үндэсний зөвлөлийн  
өдөр: 05.01.2024

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Шимтгэлийн хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хооронд байгуулсан нийгмийн хамгааллын тухай хэлэлцээр, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 7 дугаар зүйлийн 7.3.3 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. Бүгд Найрамдах Солонгос Улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй Монгол Улсын иргэдийн нийгмийн даатгалд (тэтгэврийн даатгал) албан журмаар даатгуулах шимтгэлийн хэмжээг сарын 50 000 (тавин мянга) өснөөр тогтоосугай.
2. Тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба (Г.Банзрагч)-нд даалгасугай.
4. Тогтоол батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн "Шимтгэлийн доод хэмжээг тогтоох тухай" 05 дугаар тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.
5. Энэхүү тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА

Х.БУЛГАНТУЯА



НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ



2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг тогтоох тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 35 дугаар зүйлийн 35.9.8 дахь заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг нэг ор хоногт 70 000 /далан мянга/ төгрөгөөр тогтоосугай.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас сувиллын газарт олгож байгаа санхүүжилт, үйлчилгээний чанарт тогтмол хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Л.Мөнхзул/-т үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба /Г.Банзрагч/-нд үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 16 дугаар тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэхүү тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА

Х.БУЛГАНТУЯА

1119276307  
5284708 СЕА1473



НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

Захиргааны зөв хэл  
вкүний улсын нэгдсэн  
2024 оны 01 сарын 22  
өдөр хүчин зүйл

2023 12 04

д. нө 12

Тогтоол хүчингүй болгох тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 35 дугаар зүйлийн 35.9.8 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1 "Журам шинэчлэн батлах тухай" Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 09 дүгээр тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.


2 Энэхүү тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА

Х.БУЛГАНТУЯА



НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ



2023 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 15

Улаанбаатар

Нэрийн дансны 2023 оны орлогод  
тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай


Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.7 дахь заалт, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан "Даатгуулагчийн тэтгэврийн-даатгалын шимтгэлийн нэрийн дансны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох журам", Үндэсний статистикийн хорооны саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2023 оны орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээг 14.3 хувиар баталсугай.

2. Баталсан хүүгийн хэмжээг үндэслэн даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн 2022 оны үлдэгдэл, 2023 оны орлогод тус тус хүү тооцох ажлыг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулж даатгуулагчдыг шаардлагатай мэдээллээр хангаж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Л Мөнхзул/-т даалгасугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба /Г.Банзрагч/-нд даалгасугай.

ДАРГА



Х.БУЛГАНТУЯА



НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

Захиуц № 50  
2024 оны 01 сарын 01  
одрийн 570 дугаар үйлдэл

2023 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

Тэтгэвэр авах дундаж хугацааны  
илэрхийлэл тогтоох тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг, Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 01/1091 дүгээр албан бичгээр ирүүлсэн саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу нэрийн дансны аргаар өндөр насны тэтгэвэр бодоход баримтлах тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл ("К")-ийг 2024 онд эмэгтэй даатгуулагчид 22 жил, эрэгтэй даатгуулагчид 15 жилээр тус тус тогтоосугай.

2. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 20 дугаар тогтоолын 1 дэх заалтыг "Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр бодоход баримтлах тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл ("К")-ийг 2022-2023 онд эмэгтэй даатгуулагчид 22 жил, эрэгтэй даатгуулагчид 15 жилээр тус тус тогтоосугай" гэж өөрчилсүгэй.

3. Энэ тогтоолоор баталсан тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу нэрийн дансны аргаар өндөр насны тэтгэвэр бодоход баримталж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Л.Мөнхзул/-т даалгасугай

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба /Г.Банзрагч/-нд үүрэг болгосугай.

5. Энэхүү тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ДАРГА

ХИБУЛГАНТУЯА